



Хөдөлмөр, Халамжийн
Үйлчилгээний Ерөнхий
Газар

Нийслэлийн Хөдөлмөр
Эрхлэлтийн Газар

АЖИЛД, ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

ТА АЖИЛ ХАЙЖ БАЙНА УУ?

АЖИЛГҮЙДЭЛ гэдэг нь хөдөлмөрийн зах зээл дээрх мөчлөгт үзэгдэл бөгөөд ажиллах хүчний эрэлтээс нийлүүлэлт давсан буюу нийгэм эдийн засгийн идэвхитэй хүн амын нэг хэсэг нь өөрийнхөө ажиллах хүчийг ашиглаж чадахгүй байхыг хэлнэ.

АЖИЛГҮЙЧҮҮД гэдэг нь ажил эрхэлж, орлого олохгүй байгаа бөгөөд ажил хийхэд бэлэн байгаа, сүүлийн 4 долоо хоногийн турш ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөрийн биржид бүртгэлтэй хүмүүсийг хэлнэ.


ЗАРЛАГДСАН АЖЛЫН БАЙРЫГ ДАРААХ СҮВГУУДААР ОЛОХ БОЛМЖТОЙ

- Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар
- Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
- Хороодын хөдөлмөр хариуцсан ажилтан
- Цахим бирж
- Хувийн хөдөлмөрийн бирж

2020 ОНД

Хөдөлмөрийн зах зээлд
ХАМГИЙН ИХ ҮНЭЛЭГДЭХ
10 УР ЧАДВАР

1. Асуудал шийдвэрлэх
2. Шуун тунгаах чадвар
3. Бүтээлч байдал
4. Хүн удирдах чадвар
5. Бусадтай харилцах
6. Сэтгэл хөдлөлөө удирдах бусдыг ойлгох чадвар
7. Шийдвэр гаргах чадвар
8. Үйлчилгээг эрхэмлэх
9. Гэрээ, хэлцэл хийх
10. Өөрчлөлтөд дасан зохицох



НИЙСЛЭЛД ТҮР БОЛОН БАЙНГА ОРШИН СҮҮЖ БҮЙ АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН ТА ХААНА ХАНДАЖ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ВЭ?

- Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар
- Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
- Бүртгэлд хамрагдахын тулд таны цахим үнэмлэхний мэдээлэл, нэг хувь цээж зураг хэрэглэй.
- Бүртгэлийн ажилтанд хандсанаар таныг ажил хайгч иргэний бүртгэлд авч хөдөлмөрийн зах зээлийн талаар мэдээлэл өгөн эзэмшсэн мэргэжил, хүсэл сонирхол, ур чадварт нь тохирох ажлын байранд зуучилна.

АЖИЛД ОРОХ АЛХАМ

1. БҮРТГҮҮЛЭХ
2. АЖЛЫН БАЙРАНД ЗУУЧЛУУЛАХ
3. АЖИЛ ОЛГОГЧ БАЙГУУЛЛАГАД ХАНДАХ
4. АЖИЛД ОРОХ

ЦАГИЙН АЖИЛ

Оюутан залуучууд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, их дээд сургууль, коллеж, МСУТ-ийн дэргэд байгуулагдсан “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-д хандан хичээлийн бус цагаараа цагийн ажилд зуучлуулан орлоготой болох болгомжтой.

ТҮР АЖЛЫН БАЙР

Иргэн та нийтийг хамарсан буюу түр ажлын байранд ажиллахыг хүсч байгаа бол өөрийн харьяа дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад очиж бүртгүүлэн сард ажлын 10 хүртэл хоногоор, өдөрт 8 хүртэл цагаар ажиллаж орлоготой болох болгомжтой.

Эх сурвалж:

Дэлхийн эдийн засгийн форум “Ирээдүйн хөдөлмөр эрхлэлт-2017”

АЖЛЫН ЯРИЛЦАДГАЙН ҮЕЭР АСУУЛДАГ ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

ТАНЫ ХУВЬ ХҮНИЙ ЧИГЛЭЛИЙГ ТОДОТГОХ АСУУЛТУУД

Таны боловсрол, мэргэжил ?
Энэ мэргэжлийг яагаад сонгосон бэ?
/Юугаараа таныг татсан бэ?/
Хуучин ажлаасаа яагаад гарсан бэ?

Энэ асуултуудын харилтгаас ажил олгогч таны хамгийн ерөнхий мэдээллийг олж аван тухайн компанийн үйл ажиллагааны чиглэлд таныг тохирах эсэхийг мэдэх болно. Тэгэхээр та энэ салбарт карьер хийх нэн сонирхолтой байгаа гэдгээ, мөн өөр, энэ чиглэлийн компаниудаар ч очих гэж байгаа гэдгээ хэлэх хэрэгтэй. Та өөрөө ч сонголт хийж байгаа гэдэг нь харатдана.

ТАНЫ УРМЫГ ТЭТГЭХ ХҮЧ БОЛОН ХҮСЛИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУЛТУУД

Таны амьдралын зорилтууд?
Зорилтууддаа ямар замаар хүрэх гэж байна?
Та өөрийгөө 10 жилийн дараа хэрхэн харж байна?
Та хүрсэн зорилгоосоо жишээ ярина уу,
хэрэгжүүлсэн арга зам нь?
Та өөрийгөө энэ албан тушаалд тэнцэнэ гэж бодож байгаагийн учир нь?
Та ямар цагын авахыг хүсч байна вэ?

Эдгээр асуултын харилтгаас та тухайн компанид хэр их хүч чадлаа дайчлан ажиллах гэж байгаа нь харатдана. Цалингийн хувьд битгий өөрийгөө доош нь хийгээрэй, тооцоолж байгаагаасаа 1,5 дахин их хэлэхэд ч буруудахгүй.

ТАНЫ ХУВЬ ХҮНИЙ ЧАНАРЫГ ТОДОРХОЙЛОХ АСУУЛТУУД

Та өөрийгөө таван тэмдэг нэрээр тодорхойлно уу?
Таны гурван сайн чанар?
Таны гурван муу чанар?
Таны гурван амжилт?
Таны гурван ялагдал?
Та хэрхэн амжилтанд хүрдэг вэ?
Та өнгөрсөн явдлаасаа юуг өөрчилмөөр байдаг вэ?

Энэ асуултуудын харилт нь та өөрийгөө хэрхэн дүгнэдэг, өөрийгөө хэр ойлгож чаддаг, өөртэй шүүмжлэлтэй ханддаг эсэх, алдаагаа засч чаддаг эсэхийг ажил олгогчид ойлгоно

БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭГ ТОДОРХОЙЛОХ АСУУЛТУУД

Асуудлыг хэд хэдэн замаар шийдэх жишээ ярина уу?
Ямар нэгэн асуудлыг жишээ болгон авч шийдэх арга замыг нь алхам алхмаар нь ярина уу?
Хэн нэгнийг хэрхэн санхруулж байсан жишээ ярина уу?
Зөрчилдөөнтэй байдлын жишээ аваад зөрчилдөөнөөс гарах арга замыг зурна уу?

Аливаа байгууллагын хамгийн үнэ цэнэтэй ажилтнууд бол бүтээлч сэтгэлгээ бүхий ажилтнууд байдаг. Тиймээс тухайн компанийг урьдчилан судалж үр ашгийг нь сайжруулах арга замыг хэрхэн харж байгаагаа ярьвал их сайн. Гэхдээ бүх Ноу-Хяулаа дэлгэх хэрэггүй, ерөнхийд нь яриарай.

МАНЛАЙЛАГЧ БАЙХ ЧАДВАРТАЙ ЭСЭХИЙГ ТОДОТГОХ АСУУЛТУУД

Та өөрийнхөө амьдралын зохиогч нь уу, найруулагч нь уу?
Та удирдах дуртай юу, удирдуулж ажиллах нь танд таалагддаг уу?
Та багаар ажиллах дуртай юу, ганцаараа ажиллахыг таалагддаг уу?

Энэ асуултанд харилгахдаа багаар болон хэн нэгний удирдлаган доор ажиллахдаа үр дүн сайтай ажилладаг, гэхдээ шаардлага гарвал санаачилга болон хяналтыг гартаа авч ажилладаг гэвэл та үнэлэгдэх болно.

ТА ТУХАЙН БАЙГУУЛЛАГЫГ ХЭР СОНИРХОЖ БАЙГАА, ХЭР ҮНЭНЧ АЖИЛЛАХЫГ ТОДРУУЛАХ АСУУЛТУУД

Та манай компани, байгууллагын тухай юу мэдэх вэ?
Өөр юу мэдэхийг хүсч байна вэ?
Байгууллагын гүйлгээр муу зуршлаа орхиж чадах уу?
Хэрэв танд илүү ашигтай санал ирвэл яах вэ?

Тухайн байгууллагаа судалж мэдээлэлтэй болсон байх.



www.ubbirj.ub.gov.mn



11-329752
7011 0502, 7012 0502
7013 0502, 7014 0502



Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Ерөнхий сайд Амарын гудамж
Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар
Соёлын төв өргөө "Г" корпус, 5 давхар